

ОНЦГОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, СТРАТЕГИ

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

Э.Ууганбаяр

ДХИС-ийн Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

Товч агуулга: Байгалийн аюулт үзэгдэл болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшигийн аюулын тоо давтамж, хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх алдагдаж байна. Иймд дэлхий нийтээр гамшигаас хамгаалах бодлогын баримт бичигт Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах "Аюул багатай дэлхийн төлөө" Иокохамагийн стратегийг 1994-2005 он, Улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох нь "Хёогогийн үйл ажиллагааны хүрээ 2005-2015 он, "Маргаашийн аюулгүй байдлын төлөө өнөөдөр хөрөнгө оруулцгаая" уриан дор зохион байгуулагдсан Гамшигийн эрсдэлийг бууруулах 3 дугаар чуулган болон Гамшигийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 он зэрэгт гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чадавхыг боловсронгуй болгох талаар тусгагдсан байна.

Түлхүүр үгс: Гамшиг, аюул, хүрээлэн буй орчин, гамшигийн эрсдэл

Abstract: The frequency and magnitude of disasters caused by natural hazards and human's faulty activities are increasing year by year, and people's right to live in a healthy and safe environment is being lost. Therefore, in the global disaster protection policy document, the Yokohama Strategy for Preventing and Preparedness for Natural Disasters, 1994-2005, and Building National and Local Disaster Response Capacity, Hyogo Action Framework 2005-2015. 2015-2030, the 3rd Conference on Disaster Risk Reduction organized under the theme "Let's invest today for tomorrow's security" and the Sendai Action Framework for Disaster Risk Reduction 2015-2030 have included improvements in disaster risk reduction capabilities.

Keywords: Disaster, dangerous, environment, disaster risk

Оршил

Гамшгаас хамгаалах удирдлагын ойлголт, мөн чанарын тухай авч үзэхдээ юуны өмнө удирдлага гэсэн ойлголтыг авч үзэх нь зүйтэй билээ.

Аливаа шинжлэх ухаан өөрийн судалгаанд тулгуурладаг үндсэн гол ойлголттой байдаг. Зохион байгуулалт болон удирдлагын

салбарын тэргүүний онолч, менежментийн эцэг гэж нэрлэгдэх болсон Питер Ф.Друкер "Удирдлага гэдэг нь зохион байгуулалтгүй бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бүтээмжтэй бүлэг болгон өөрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм" гэж тодорхойлжээ. Удирдлага бол байгууллагын зорилтуудыг томьёолж түүнд хүрэхийн тулд зайлшгүй

төлөвлөх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хянах үйл явц юм гэж үзэж болно. Удирдлага болон менежмент ойролцоо утгатай үг боловч тус тусдаа бие даасан ойлголт юм. “Менежмент”- Management– англи үг орчуулбал “удирдлага” – оросоор- “управление” гэдэг.

Менежмент гэдэг нь байгууллагын зорилтыг тодорхойлж, түүнд хүрэх замыг нарийн тодорхойлж, үйлдвэрлэлийн нөөцүүдийн ашиглалтыг оновчтой зохион байгуулж, хүмүүсээ идэвхижүүлэн манлайлж, улмаар ажлын үр дүнг үнэлэн хянан тавих үйл ажиллагаануудын нэгдэл юм. Менежмент гэдэг англи үг захирах, удирдах, тушаах, гүйцэтгэх, чиглүүлэх, эхлүүлэх, хянах, шалгах, хөтлөх, жолоодох, арга эвийг олох, нөлөөлөх гэх мэт 30 гаруй утга санааг илэрхийлдэг. Харин эрт цагийн монгол сэтгэлгээнд менежмент гэсэн ойлголт засах ухаан хэмээх ойлголтоор гарч ирдэг байна.


Байгууллага гэдэг нь өмнөө тавьсан тодорхой зорилгод хүрэхийн төлөө үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулж байгаа бүлэг хүмүүс юм. Энэ тодорхойлолт нь албан ёсны байгууллагад хамаарах ба үүний зэрэгцээ албан ёсны бус байгууллага гэж байдаг.

Нэг. Гамшгийн менежмент

Онцгой байдлын байгууллага нь Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулдаг.

Гамшгийн удирдлага (Disaster management) гэж: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн өмчийн хэлбэрийг үл харгалзан зохион байгуулна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг эрдэмтэн судлаачид дараах гурван үе шатаар ангилан хувааж үздэг. Үүнд:



Зураг 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт.
П.Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, УБ., 2018, 80 дахь тал

Гамшгаас хамгаалахад бэлтгэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах буюу хор уршгийг арилгах, гамшгийн дараа сэргээн босгох ажлыг зохион байгуулах, төлөвлөх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гамшгаас хамгаалах удирдлага гэнэ¹. Өөрөөр хэлбэл, гамшгийн төрөл бүрийн (гамшгийн өмнөх, гамшгийн үе, гамшгийн дараа) үе шатанд удирдлагын түвшинг (стратегийн, оператив-тактикийн, тактик-үйл ажиллагааны) авч хэрэгжүүлэх үндсэн бодлого, засаг захиргааны шийдвэр, шуурхай үйл ажиллагаа гэж үзэж болно.

Гамшгаас хамгаалах удирдлагын зорилго нь:

- Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учирч болох гамшгийн болзошгүй хохирлыг бууруулах,

хэрэв боломжтой бол бүр мөсөн арилгах.

- Гамшгийн аюулд нэрвэгдэгсдийг аврах, яаралтай бөгөөд нэн хэрэгцээтэй тусламж үзүүлэх.

- Урьд өмнө байсан эрсдэлээс бага эрсдэлтэй болгохын тулд үр дүнтэй, урт хугацааны сэргээн босгох арга хэмжээг авахад оршино.

Монгол Улсын 2017 онд батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын бүтцийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг төлөвлөх,

¹ <https://www.preventionweb.net/english/professi>

onal/terminology/ United Nations Office for Disaster Risk Reduction (UNISDR)

хэрэгжүүлэхийг хэлнэ¹ гэжээ. Эдгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлэх удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг гамшгаас хамгаалах удирдлага, гамшгаас хамгаалах менежмент, гамшгийн менежмент гэх зэргээр олон янзаар нэрлэж байна. Гэтэл удирдлага, менежмент гэдэг үг нь хоёр өөр утгыг илэрхийлдэг. Иймд энэ хоёр үгийн утгыг маш сайн ойлгож байж удирдлагыг удирдлага гэдэг утгаар нь, менежментийг менежмент гэдэг утгаар нь хэрэгжүүлж тавьсан зорилгодоо хүрч чадна².

Нийгмийн аливаа үйл хэрэг тодорхой чиглэл, зорилготой, удирдлагын хүрээнд явагддаг. Хүссэн үр дүндээ хүрэхийн тулд удирдлагадаа байгаа хүмүүс болон объектуудын үйл ажиллагааг чиглүүлэх зорилгоор удирдах байгууллагын субъектүүдээс тэдгээрт үзүүлж байгаа ухамсартай бөгөөд чиглэсэн зорилготой нөлөөллийг удирдлага гэнэ³.

Удирдлагын объект нь байгаль, нийгэм, эдийн засгийн бүх салбар, техник, тоног төхөөрөмж бүх зүйл байдаг бөгөөд байгууллагын хувьд зорилгыг тодорхойлох, түүнд хүрэхийн тулд нөхцөл байдлыг үнэлэх, төлөвлөх, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хянаж шалгах үйл ажиллагааны тухай ухаан юм.

Өөрөөр хэлбэл удирдлага гэдэг нь үйл ажиллагааны хувьд тухайн объектыг залж чиглүүлэх үүрэгтэй субъектуудээс өмнөө тавьсан зорилго, зорилтдоо хүрэхийн тулд хийх ажлын дараалал, баримтлах зарчим, хэрэглэх арга, арга зүйг тодорхойлсон онол ба практик үйл ажиллагааны цогц юм. Харин энэ бүгдийг судалдаг шинжлэх ухааныг удирдлагын шинжлэх ухаан гэдэг. Удирдлагын шинжлэх ухааны нэг гол судлагдахуун нь менежмент байдаг.

Гамшгаас хамгаалах удирдлага зохицуулалт нь гамшгаас хамгаалах Улсын алба, яам, агентлаг, орон нутгийн байгууллага, Онцгой байдлын байгууллага, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, эдгээр асуудлаар цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хамгаалах талаарх бодлого төлөвлөлт, удирдлага зохицуулалтыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гамшгийн өмнөх удирдлага: Гамшгаас хамгаалах салбар дундын үйл ажиллагааны удирдлага нь тухайн нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй гамшгийн үед гарч болох эрсдэлийг тодорхойлохын тулд эрсдэлийн

¹ Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт

² Даш П, Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийн удирдлага, УБ., 2018, 7 дахь тал,

³ Райзберг Б.А, Лозовский Л.Ш, Стародубцева Е.Б Современный экономический словарь, <http://www.smartcar.ru/Referat/>

үнэлгээ хийх, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гамшгаас хамгаалах бодлого, стратегийг боловсруулах, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн үед тохиолдох эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, бэлэн байдлыг хангах зэрэг арга хэмжээг зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.

Гамшгийн үед түүний хор уршгийг яаралтай арилгах, гамшгийн дараа түргэн хугацаанд сэргээн босгох асуудал гамшгийн эрсдэлийг бууруулахад багагүй нөлөөтэй байдаг тул гамшгийн эрсдэлийн удирдлага гамшгийн үед болон дараа ямар нэгэн хэмжээгээр явагдаж байдгийг санах хэрэгтэй¹.

Манай орны түүхэн байдлаас үзэхэд, гамшгаас хамгаалах удирдлага нь гамшгийн аюулыг бууруулах үйл ажиллагаанд ихээхэн анхаарч ирсэн байдаг. Сүүлийн жилүүдэд НҮБ, Гамшигтай тэмцэх олон улсын байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас хийсэн судалгаагаар улс орны тогтвортой хөгжлийг хангахад гамшгаас хамгаалах салбарууд эрсдэлийг бууруулах нь онцгой ач холбогдолтой байна гэдгийг нэгэнт тогтоогоод байгаа билээ. Үүний тулд хоёр гол зүйл дээр анхаарч ирсэн байна.

Нэгдүгээрт, төлөвлөлт эрсдэлээс хамгаалах, эрсдэлгүй байх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн байж тогтвортой хөгжлийг хангаж чадна.

Хоёрдугаарт, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгө мөнгө гаргах замаар гамшгаас учрах хохирлыг багасгах боломжтой гэж үздэг.

Эрдэмтдийн гаргасан тооцоогоор урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан нэг доллар гамшгийн дараа зарцуулах 7 долларыг хэмнэнэ гэж байсан бол сүүлийн үеийн судалгаагаар 35 долларыг ч хэмнэх боломжтой гэж үзсэн байна. Үүнтэй холбоотойгоор Азийн хөгжлийн банк 2009 онд Ази, Номхон далайн бүсийн гамшгийн эрсдэлийг бууруулахад туслах механизмаа боловсронгуй болгох зорилгоор "Байгалийн гамшгаас хамгаалах Ази-Номхон далайн сан" гэдгийг байгуулаад 2010 оны сүүлчээс эхлэн улс орнуудад зонхилон тохиолддог газар хөдлөлт, зуд, үер, цунами, далайн хар салхи, галт уулын дэлбэрэлт зэрэг зургаан төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад зориулан санхүүжилтийг хийж эхэлсэн байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх: гэж гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах замаар гамшгаас үүсч болзошгүй

¹ Даш П, Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийн удирдлага, УБ., 2018, 10 дахь тал

сөрөг үр дагаврыг хязгаарлах, гамшгийн үед шуурхай ажиллах чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэж аюулын сөрөг нөлөөллөөс шууд зайлсхийх үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны, технологийн, биологийн холбогдох гамшгийг хамгийн бага болгох хэрэгслийг хэлнэ. Нийгмийн болон техникийн боломж, зардал, ашгаас шалтгаалан гамшигт байнга нэрвэгддэг газруудад урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгө оруулах нь зүйтэй байдаг. Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлага болон зан үйлийг өөрчлөх нь “урьдчилан сэргийлэх соёл”-ыг төлөвшүүлэхэд нэмэр болно.

Хэдийгээр урьдчилан сэргийлэх гэдэг үгийг зарим улс орны судлаачид өргөн хэрэглэдэг боловч энэ үгийн утга нь гамшгийн эрсдэлийг урт хугацаагаар бууруулах санааг агуулдаг юм. Учир нь зарим гамшгийн аюулаас бүрэн урьдчилан сэргийлэх боломжгүйд оршино.

Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ нь “хамгаалалтын хоёр дахь зурвас” гэж судлаачид үздэг юм. Энэ арга хэмжээний үндсэн зорилго нь гамшиг гарсан үед аврах ажиллагаа явуулах, хор уршгийг хэрхэн шуурхай бөгөөд үр дүнтэй арилгах, гамшгийн үед гарч болзошгүй бэрхшээлийг урьдчилан төсөөлсний үндсэн дээр тэдгээрийг хэрхэн

оновчтой шийдвэрлэх талаар зохих бэлтгэлийг хангахад оршино.

Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээг хийх, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах, гамшигтай тэмцэх салбарууд ба хүн амын дунд холбогдох сургалтыг зохион байгуулах, гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх ажлыг тогтмол явуулах, зохих нөөц, хүн, хүч хэрэгслийг бүрдүүлэх, зарлан мэдээллийг шуурхай дамжуулах зэрэг ажлууд орно.

АНУ-ын гамшгийн удирдлагын судлаач Фредерик Кьюнигийн хэлснээр “Гамшгаас хамгаалах удирдлагын салбарт хамгийн их боломж, бололцоо олгодог үе нь бэлэн байдлыг хангах үе” гэжээ. Үнэхээр бэлэн байдлыг цаг тухайд нь хангах явдал маш их ач холбогдолтой байдаг юм.

Гамшгийн үеийн удирдлага: нэрвэгдэгсдийг эрэн хайх-аврах, яаралтай тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах чухал арга хэмжээнүүдийг авч явуулна.

Гамшгийн үед үүсч бий болсон нөхцөл байдлыг богино хугацаанд үнэлэн шийдвэр гаргаж хүч хэрэгслээ зохистой хуваарилан аврах, эрэн хайх үйл ажиллагаа явуулна. Энэ үед дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт зэрэг улс орныг хамарсан томоохон ажлууд хийгдэхээс гадна нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, үндсэн дэд бүтцийг яаралтай сэргээн босгох, хохирлын үнэлгээ хийх зэрэг

гамшгийн дараа хийвэл зохих ажлууд хийгдэж эхэлнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын тусламж хүсэх хэрэгцээ ч гарна. Удирдлагыг хэр оновчтой, шуурхай явуулснаас учрах хохирол буюу эрсдэлийн хэмжээ хамаарна.

Гамшгийн голомтоос аврах ба хор уршгийг арилгах үеийн удирдлага Гамшгийн аюул тохиолдсон үед болон түүний хөнөөлийн дараа эрэн хайх, авран хамгаалах, яаралтай тусламж үзүүлэх хийгээд бусад хор уршгийг арилгах хойшлуулшгүй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Аврах гэж гамшгийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, гал түймрийн шаталтыг зогсоох, унтраах, нэрвэгдэгсдэд анхны тусламж хүргэх, гамшгийн аюулын голомтоос гаргах үйл ажиллагааг хэлнэ.

Хор уршгийг арилгах гэж гамшгийн аюулын үед хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах зэрэг гамшгийн аюулыг гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг хэлнэ.

Хор уршгийг арилгах хойшлуулшгүй арга хэмжээнд нэрвэгдэгсдийг аврах, эмнэлгийн тусламж үзүүлэх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, хоргодох байр, хүнсээр хангах, холбоо мэдээллийг зохион

байгуулах, ус ундны хангалт хийх, эрүүл мэнд, ариун цэврийг сахин хамгаалах, зам харгуйг чөлөөлөх, чухал объектыг сэргээх болон бусад арга хэмжээ орно.

Хэдийгээр гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ богино хугацааны үйл ажиллагаа ч гэсэн энэ арга хэмжээ нь ирээдүйд эмзэг байдлыг бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлдэг юм. Иймд гамшгийн хор уршгийг арилгах үед холбогдох байгууллагууд сэргээн босгох ба засварлах арга хэмжээг төлөвлөнө.

Гамшгийн дараах удирдлага Хойшлуулшгүй сэргээн засварлах ба сэргээн босгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Гамшгийн дараа нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, гамшигт өртсөн дэд бүтэц, объектуудыг сэргээн босгох, гамшигт нэрвэгдсэн байгууллага, аж ахуйн нэгж, хүмүүсийн үйл ажиллагааг сэргээн хэвийн байдалд оруулах нөр их ажил өрнөдөг. Энэ нь хэд хоног, хэдэн сар, хэдэн жилээр ч үргэлжилдэг асар их хүч хөдөлмөр шаардсан ажил юм. Ийм учраас гамшгийн дараах удирдлага нь зөвхөн Онцгой байдлын байгууллагын үүрэг төдий биш төв, орон нутгийн онцгой комисс, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, Засгийн газар, Улсын Их Хурлын түвшинд ч явагдаж болох өргөн цар хүрээтэй удирдлага юм. Энэ удирдлагын үед нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хохирлын үнэлгээг нарийвчлан хийх,

хор уршгийг бүрэн арилгах, сэргээн босгох, сэргээн засварлах, тэсвэрлэх чадавх болон бат бөх чанарыг нэмэгдүүлэх гэх мэт маш олон арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Гамшгийн үеийн удирдлага шиг олон улсын тусламж дэмжлэг авах шаардлага ч гардаг байна. Дээр дурдсан бүх үйл ажиллагааг сэргээн босгох ажиллагаа гэж үздэг тул сэргээн босгох ажиллагааны удирдлага гэж ч хэлж болно

Хоёр. Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн удирдлага

Сэргээн босгох болон сэргээн засварлах арга хэмжээ нь ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдэж, тухайн улс орны үндэсний хөгжлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг байх болно.

Хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд хэд хэдэн гол ажлууд хийгдэнэ. Үүнд:

- Үйлдвэр, үйлчилгээг сэргээн босгох, засварлах;
- Орон сууц, барилга байгууламжийг сэргээн засварлах;
- Түр орогнох байруудыг барих;
- Гамшгийн улмаас нэрвэгдсэн хүмүүсийн бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл санааг сэргээхэд чиглэгдсэн эрүүл мэнд, хүмүүнлэгийн арга хэмжээнүүдийг авах;
- Гамшгийн улмаас эвдэрч сүйрсэн барилга байгууламж, дэд бүтцийг шинэчлэн байгуулах урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлэх гэх мэт.

Гамшгийн дараах бүрэн хэмжээний сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд улс орны хөгжлийн асуудалд зориулагдсан төсөв нөөцөөс зохих хэмжээгээр хөрөнгө гарч хөгжлийн эрч хүч саарахад хүрнэ. Мөн хүн ам олноороо дүрвэх, нүүх зэрэг бусад сөрөг үр дагавар байж болно. Хүн амын хөдөлгөөн, гэр орноос дайжсан хүмүүсийн бөөгнөрөл нь халдварт өвчин гарах, хүрээлэн буй бүс нутгийнх нь ой мод болон эдийн засгийн эмзэг салбар сүйрэх эсвэл өлсгөлөн болох гэх мэт бусад олон тулгамдсан асуудлуудыг бий болгож болох юм. Эдгээр сөрөг үр дагаврууд нь орон нутаг, улсын хэмжээнд эсвэл олон улсын хэмжээнд гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага хэрэгцээг бий болгодог. Хэрэв энэхүү хор уршгийг арилгах арга хэмжээ нь урьдчилан бодож төлөвлөгдсөн байвал илүү үр дүнтэй байх болно.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын талаар Монгол Улсын “Гамшгаас хамгаалах тухай” хуульд “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд


тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ¹” гэж заажээ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний удирдлага дор улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага нь харилцан ажиллагааг удирдан зохион байгуулна.

Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан харилцан ажиллагааг ханган хэрэгжүүлж

байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих зорилгоор Улсын онцгой комисс, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулж ажиллуулна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, үүссэн цагийн байдалтай холбогдуулан МУЗГ, УОК нь аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн захиргааны болон төрийн бус олон нийтийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хангаж тэдгээрийн оролцоог уялдуулан зохицуулна.




Зураг 2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны улсын хэмжээний удирдлага, зохион байгуулалтын бүтэц

¹ Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1. дэх заалт

Онцгой байдлын ба тусгай чиг үүрэг бүхий байгууллага, гамшгаас хамгаалах Улсын болон орон нутгийн албад, төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагын харилцан ажиллагааг түүнд оролцогч,

зохион байгуулагчийн зиндаа, бүрэлдэхүүний байдлаас хамаарч удирдлагын *стратегийн, оперативын, тактикийн* түвшинд хуваан үзэж байна.



Зураг 3. Гамшгийн үеийн удирдлагыг стратегийн, оперативын, тактикийн 3 түвшингийн ангилал

№	Түвшин	Холбогдох субъектүүд
1.	Стратегийн удирдлага	- Монгол Улсын Засгийн газар - Монгол Улсын Шадар сайд, УОК - ОБЕГ, Гамшгаас хамгаалах Улсын албадын хэмжээнд /тухайн гамшиг, осол, сүйрлийн төрлөөс хамааран нь аль байгууллага ахлах нь тодорхойлогдоно. Тухайлбал, Хүний гоц халдварт өвчин гарсан үед - ЭМЯ, Малын гоц халдварт өвчин, зуд болсон үед - ХХААХҮЯ, Уул уухай, газрын тосны томоохон сүйрэлд- УУХҮЯ, Түлш эрчим хүчний холбогдолтой сүйрлийн үед – ЭрчХЯ, Гал түймэр, газар хөдлөлт, үер усны үед – ОБЕГ, Цацрагийн осолд- ЭМЯ, МХЕГ, ОБЕГ, Терорист үйл ажиллагааны үед – ХЗЯ, ЦЕГ, ТЕГ, ЗХЖШ гэх мэт/ хамтран зохион байгуулна. - Энэ нь гол төлөв ажиллагааны гэхээсээ илүүтэй дүрэм, журам, заавар, урьдчилсан төлөвлөлтийг боловсруулснаар явагдана.
2.	Оперативын удирдлага	- Аймаг, нийслэлийн удирдлага, онцгой комисс - Гамшгаас хамгаалах алба - ОБЕГ-ын газар, хэлтэс, Төв, орон нутгийн ОБГ, хэлтэс, аврах бригад, аврах анги, ЗХЖШ, ХЦЕГ-ын тусгай мэргэжлийн ангиудын хооронд зохион байгуулна. - Энэ нь гол төлөв шуурхай шинж чанартай байна.
3.	Тактикийн удирдлага	- Сум, дүүрэг орон нутагт гарсан гамшиг, ослын үед аврах салаа, МА, шуурхай болон жижиг бүлгүүдийн хооронд зохион байгуулах бөгөөд гол төлөв аврах ажиллагааны шинж чанартай байна. - Дээд штабаас томилогдсон шуурхай бүлгүүдийн дунд зохион байгуулагдаж болно.

Хүснэгт 1. Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Гамшгаас хамгаалах салбар болон түүнд оролцох субъект

Дээрх хүснэгтэд зааснаар стратегийн харилцан ажиллагааг Монгол Улсын Шадар сайд, УОК, ОБЕГ, Улсын албад, төрийн захиргааны төв байгууллагын хэмжээнд хамтран зохион байгуулна. Энэ нь гол төлөв ажиллагааны гэхээсээ илүүтэй дүрэм, журам, заавар, урьдчилсан төлөвлөлтийг боловсруулснаар явагдах нь зохимжтой байна.

Оперативын

удирдлага зохицуулалтын ажиллагааг аймаг, нийслэлийн удирдлага, онцгой комисс, гамшгаас хамгаалах Улсын алба, ОБЕГ-ын газар, хэлтэс, Төв, орон нутгийн ОБГ, хэлтэс, аврах бригад, аврах анги, ЗХЖШ, ХХЕГ-ын тусгай мэргэжлийн анги, шуурхай штабуудын хооронд зохион байгуулна. Энэ нь гол төлөв шуурхай шинж чанартай байна.

Тактикийн харилцан ажиллагааг аврах тасаг, салаа, жижиг бүлгүүдийн хооронд зохион байгуулах бөгөөд гол төлөв аврах ажиллагааны шинж чанартай байна. Эндээс харахад харилцан ажиллагааны дээрх хэлбэр нь удирдлага, оролцогч бүрэлдэхүүнээс ихээхэн хамааралтай болох нь илэрхий байна.

Дүгнэлт

Менежментийн ухааны үүднээс удирдлага зохион байгуулалтыг дээд, дунд, доод удирдлага нь дээрх харилцан

ажиллагааны түвшинтэй уялдаж байна.

Харилцан ажиллагааны төлөвлөлтийг боловсруулахад гамшгаас хамгаалах сургалтыг оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Цаашид зөвхөн газар хөдлөлтийн гамшгийн аюулаас гадна нийтийг хамарсан гамшгийн нөхцөл бий болсон үед төрийн цэргийн харилцан ажиллах эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллах талаар холбогдох хуулийн заалтыг тусгаснаар харилцан ажиллагаа нь хэрэгжих нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Гамшгийн нөхцөл байдал бий болсон үед төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллах талаар хууль тогтоомжийн заалтыг тодорхой болгож, гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн хэлбэрээр гүйцэтгэх эрх үүргийг зааглаж өгснөөр гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулахад гүйцэтгэх чиг үүрэг тодорхой болно гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, УБ., 2017

- Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ, УБ., 2015.

- П.Цэдэв, С.Бямбасүрэн, “Гамшиг, олсын үеийн харилцан ажиллагааны онол, арга зүйн үндэс”, “Корона халдварын цар тахлын үеийн шинэ хэв маягт дасан зохицох

нь”, Онол практикийн эмхэтгэл, УБ., 2021

- П.Даш, Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийн удирдлага, УБ., 2018

- П.Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, УБ., 2018

- Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, УБ., 2017